



# СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

# МЭДЭЭ

154 /154/

2021.10.12

## Цахим шууданд

## ХОВДЫН ХОРОО ОФИЦЕР, АХЛАГЧИЙН ТҮВШИН ТОГТООХ ҮЗЛЭГТ АМЖИЛТТАЙ ХАМРАГДЛАА



### Зэвсэгт хүчний 123 дугаар анги

Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн офицер, ахлагч нар, Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын бие бүрэлдэхүүн түвшин тогтоох үзлэгт хамрагдлаа.

Анги "Түвшин тогтоох үзлэгт бэлтгэх төлөвлөгөө"-г цэргийн алба хаагчдын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хагас жилийн тайлан, бүх төрлийн социологийн судалгаа, бие бялдрын бэлтгэлжилт, эрүүл мэндийн байдал, мэргэжлийн ур чадвар зэрэг таван төрлөөр боловсруулан бэлтгэж амжилттай шалгууллаа.

Үзлэгийн төгсгөлд ЗХЖШ-ын Сургалтын бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга, комиссын нарийн бичгийн дарга, хурандаа Ш.Гантулга дүгнэн хэлэхдээ "Цэргийн жинхэнэ албаны офицер, ахлагчийн түвшин тогтоох үзлэгээр та бүхний ажлын гүйцэтгэл, албаны хандлага, үр дүн, сахилга хариуцлага, ёс зүй, сэтгэл зүйн бэлтгэлжилт, эрүүл мэндийг үнэлж дүгнэх, цэргийн алба хаагч бүр өөрийн түвшнээ тодорхойлж, цаашид ямар зүйл дээр анхаарч ажиллахаа сайтар төлөвлөх хэрэгтэй" хэмээгээд зарим үүрэг чиглэл өглөө.



## "БҮХ НИЙТЭЭРЭЭ МОД ТАРИХ ӨДӨР" АЯНЫГ ӨРНҮҮЛЛЭЭ

Ховд аймаг "Тэрбум мод" хөтөлбөрийн хүрээнд энэ сарын 4-9-ний өдрүүдэд "Бүх нийтээрээ мод тарих өдөр" аяныг өрнүүлээ. Уг аянд ангийн бие бүрэлдэхүүн нэгдэж 330 ширхэг мод худалдан авч Буянт голын дагуу 230 ширхэг бургас, 100 ширхэг улиас тарив. Мөн цэргийн гэрээт болон хугацаат албаны дайчид ангийн байрлалд 300 ширхэг шар хайлс, 250 ширхэг улиас мод тарьж, ангийн ногоон байгууламж эко орчинг бүрдүүлэхэд хамт олон идэвх зүтгэлтэй оролцлоо.

Ахмад У.БАТЦЭНГЭЛ

## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 321,190 +1348	ЭДГЭРСЭН 398,930 +6477	НАС БАРСАН 1377 +14
-----------------------------------	---------------------------	------------------------

## ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 5543 +97	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ 196	ЭДГЭРСЭН 5239
-----------------------------	----------------------------	------------------

## КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 239,009,337
Эдгэрсэн Нийт: 216,246,730
Нас барсан Нийт: 4,872,405

## Түүхэнд энэ өдөр

### 1921 он:

Хатанбаатар С.Магсаржав Ховд зэрэг газрыг дайлаар мордох цэргийг захирах жанжны тамгыг хүлээн авч, Баруун хязгаарыг цагаантнаас чөлөөлөхөөр морджээ.

### 1993 он

"Монгол Улсын Батлан хамгаалах тухай хууль" батлагдсан.

## ЦАГ АГААР

### УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
9	-5

### ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
30	22

## ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,848.00	2,850.00
EUR	3,303.0	3,315.0
CNY	442.00	443.00
RUB	39.30	40.20
JPY	24.85	25.35
KRW	2.33	2.42

## ЗУРХАЙ

2021.10.12 МЯГМАР ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЫН 7/

НАМРЫН АДАГ ШАР НОХОЙ САРЫН ХОЁР ХАР ХАРАГЧИН МОГОЙ ӨДӨР

Үс засуулбал:

Хэл ам, хэрүүл тэмцэл ирнэ.

Наран ургах, шингэх:

07.07-18.10

Барилдлага:

Үхэх

Шүтэн барилдлага:

Тийн мэдэхүй

Суудал:

Уул

Тухайн өдөр үхэр жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адеуус муулах, хараал, жатхыг буцаах, газар лусын зан үйл хийх, ер барагдуулах, гэр бүрэхэд сайн. Ургаа мод таслах, газрын ам нээх зэрэг үйлд муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

Цахим шууданд

# БАТАЛЬОНЫ ХОНОГИЙН СУРГУУЛЬ АМЖИЛТТАЙ БОЛЖ ӨНДӨРЛӨЛӨӨ



Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төвд БНӨСУ-д үүрэг гүйцэтгэх XI ээлжийн мотобуудлагын батальоны бие бүрэлдэхүүн энхийг дэмжих ажиллагааны сургалтын төвийн багш нартай хамтран энэ сарын 8-9-ний өдрүүдэд байгаль, цаг уурын хүндэрсэн нөхцөлд хоногийн сургуулийг төлөвлөгөөний дагуу амжилттай зохион байгууллаа.

Хоногийн сургуулиар батальоны хэргийн байрлалын район, танк дром, хот доторх байлдааны ажиллагааны дадлагын

цогцолбор, буудлагын полигон, шалган нэвтрүүлэх цэгийн дадлагын цогцолбор, Сургалтын төвийн буудлагын дасгал боловсруулах цогцолборт НҮБ-ын баазын харуул хамгаалалт, эргүүл, цувааны хамгаалалтыг зохион байгууллаа. Түүнчлэн цагийн байдлыг хөгжүүлэх төлөвлөгөөний дагуу үүссэн цагийн байдалд хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэн бие бүрэлдэхүүний мэдлэг, ур чадварыг бататгасан үр дүнтэй сургууль болж өндөрлөлөө.



"Тэрбум мод" үндэсний хөтөлбөр

## "ТЭРБУМ МОД" ХӨДӨЛГӨӨНД НЭГДЛЭЭ

**Зэвсэгт хүчний 339 дүгээр анги**  
Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх НҮБ-ын Ерөнхий Ассамблейн хуралд үг хэлэхдээ Монгол Улс нэг тэрбум мод тарихаа мэдэгдсэн.

Энэ хүрээнд "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг орон даяар өрнүүлэх ажлыг Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн

түүчээлж 22 сая мод тарихаар төлөвлөн хэрэгжүүлж эхлээд байгаа бөгөөд Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн бие бүрэлдэхүүн ангийн байрлал болон Баянхонгор аймгийн Баянхонгор хотын районд мянга орчим шар хус, хайлаас модны үрсэлгээг тарих үйл ажиллагаа болж өрнөлөө.

Тус ангийн захирагчийн материал

хэрэгслийн хангалт хариуцсан орлогч, хошууч С.Зоригтбүргэд "Бид бүхэн ангийн байрлал болоод тус аймгийн эко, ногоон хөгжилд уриалсан хөдөлгөөн, арга хэмжээнд маш идэвхтэй оролцдог. Өмнө нь манай ангийн алба хаагчид 500 орчим мод тарьсан. Цаашид ч энэ хөдөлгөөнийг үргэлжлүүлэн аймагтаа манлайлагч байгууллага болохоор зорилт тавин ажиллаж байна" гэв.



## 550 БУТ, ЧАЦАРГАНЫН МОД ТАРИВ



**Зэвсэгт хүчний 120 дугаар анги**  
"Тэрбум мод" тарих үндэсний хөдөлгөөн болон Артиллерийн цэрэг үүсэж хөгжсөний 100

жилийн ойтой уялдуулан Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн худгийн моторчин Ж.Болормаа 500 эм бут, 50 эр бут, чацарганын үрсэлгээг ангидаа

хандивлав. Үүнийг өнгөрсөн амралтын өдрүүдээр ангийн бие бүрэлдэхүүн ангийн байрлалд технологийн дагуу тариалав.


**Ахмад П.БЭХБАТ**



Дарга, ерөнхий редактор, хурандаа **САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ**



**ЦАХИМ ХАЯГ**  
Батлан хамгаалах яам  
Зэвсэгт хүчний Жанжин штаб



**ЦАХИМ ХУУДАС**  
"Соёмбо" сонин  
"Дуулга" студи

\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.  
\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.  
\* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон  
Индекс: 10018

Цахим шуудан:  
Soyombo@mod.gov.mn  
Утас: 70001029, 3412 (дотуур)